

ЛОН-ИТ БУЛИГААР ХК

2020 оны үйл  
ажиллагааны  
тайлан



**BULIGÁR**

BOVINE SKIN TANNERY

EST. 1934

Хаяг: ХУД, 2-р хороо, АШИХ  
E-mail: [buligaar1934@gmail.com](mailto:buligaar1934@gmail.com)



## Компанийн ерөнхий танилцуулга



Монгол улсын анхны арьс шир боловсруулах үйлдвэр болох “Мон-Ит Булигаар” ХК нь 1934 байгуулагдаж одоогийн үйлдвэр нь 1976 онд БНСЧУ-ын техник эдийн засгийн тусламжаар жилд 375 мянган бодын шир үйлдвэрлэх зориулалттайгаар ашиглалтад орсон юм. Улмаар 1995-1998 онуудад техник, технологийн иж бүрэн шинэчлэлт хийн жилд 500 мянган бодын шир гүйцэт боловсруулах буюу 1,150 мянган квадрат метр эцсийн боловсруулалт хийсэн арьс шир болон 2,2 сая богийн арьс гүн боловсруулалт хийхээр 1998 оны 12-р сард ашиглалтад орсон.

2009 онд бүх гишүүдийн хурлаар “Мон-Ит Булигаар” ХК нэртэй болсон. Тус компани нь 60 ажилтнуудтай, үүний дотор мэргэжлийн инженер техникийн ажилтан 8, эдийн засаг, санхүү, хүний нөөц, маркетингийн мэргэжилтэн 6, тоног төхөөрөмжийн мэргэжлийн ажилтан 3, технологийн мэргэжлийн ажилтан 33 хүн тус тус ажиллаж байна. Инженер техникийн ажилтнууд Турк улс болон хөгжилтэй орнуудад үйлдвэрлэлийн дадлага хийсэн. Нийт ажилтнуудын 60 гаруй хувь нь мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан ажилтан байдаг.

## Үйлдвэрлэлийн хүчин чадал



- Мон-Ит Булигаар ХК-ийн арьс шир боловсруулах үйлдвэрлэл нь нойтон болон хуурай боловсруулалтын 25 технологийн дамжлагатай.

- Боловсруулалтын нэг өдрийн оролт нь 1500-2000 үхрийн шир бөгөөд технологийн цикл нь зундаа 21 хоног, өвөлдөө 25 хоног байдаг.

- Бод, богийн арьсыг хагас болон гүйцэт боловсруулан вэт-блю, краст, булигаар, гялгар хром, артай хар хром, гутлын дотор зэргийг үйлдвэрлэн дотоод болон гадаадын зах зээлд борлуулдаг бөгөөд үндсэн хэрэглэгчид нь Монгол улсын гутлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд юм. Боловсруулсан гутлын арьсыг нийлүүлэхэд одоогийн байдлаар 30 гаруй гутлын болон жижиг эдлэлийн үйлдвэрлэгч нарт нийлүүлж байна.

Химийн боловсруулах цех тоног төхөөрөмжийн хүчин чадлаараа ажиллахад нэг өдөрт:

Үхэр – 800 ширхэг,

Хонь – 3500 ширхэг,

Үхэр – 240 ширхэг,

Хонь – 1000 ширхэг арьсыг ветблю болгож суурь будаг хийх хүчин чадалтай .



## Барилга болон тоног төхөөрөмжийн засвар, ашиглалт үйлчилгээний тухай

Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, барилгын шинэчлэлт, үйл ажиллагаагаа сайжруулахад дотоод нөөц бололцоондоо тулгуурлан томоохон ажлууд хийсэн. Үүнээс дурьдвал, компанийн тоног төхөөрөмжийн үндсэн зориулалт нь бодийн арьс боловсруулах байсанг тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, махлах машин /2 ширхэг/, индүү буюу нойтон сунгах машин /1 ширхэг/ зэрэг тоног төхөөрөмжийг шинээр худалдан авсан.

Ингэснээр богийн арьсыг гүйцэд боловсруулах тоног төхөөрөмжийн шаардлага хангаж, бүх төрлийн богийн арьс боловсруулах хүчин чадалтай болж, улмаар богийн арьс их хэмжээгээр үйлдвэрлэл эхэлсэн. Түүнчлэн удаан хугацаанд ажиллах боломжгүй гэмтэлтэй байсан шүрших агрегат машин, молисса буюу раман хатаалгын машин зэрэг тоног төхөөрөмжид их засвар хийж ажиллагаанд оруулсан.

Төв хаалганы хэсгийг шинэчлэн засварласан, мөн 2-р давхрын шатыг хэсэгчлэн засварласан, ажилтнуудын хувцас солих өрөө болон амралтын өрөөг иж бүрэн тохижуулан засварласан, түүнчлэн ачааны лифтний урсгал засварын ажил, 5-р давхрын засвар шинэчлэлтийн ажил болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.





## Экспорт болон харилцагч байгууллагууд



- Манай үйлдвэрийн хувьд өнөөдрийн байдлаар Турк, БНХАУ зэрэг улс руу хонь болон ямааны арьсыг wet-blue түвшинд боловсруулан нийлүүлж байна. Цаашид илүү нэмүү өртөг шингээж, Испани, Турк, Энэтхэг, БНХАУ зэрэг орнууд руу үхрийн арьсыг крастын түвшинд экспорт хийхийг зорин ажиллаж байна.

### ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛАГУУД:

Арьс ширийг боловсруулахад сайн тоног төхөөрөмжөөс гадна мэдээж химийн материал нь үндсэн гол үүргийг гүйцэтгэж байдаг. Химийн материал, будагч бодисыг сонгохдоо мэдээж тухайн технологид үйлчилж буй чанар болон үнээр нь харьцуулан сонгох хэдий ч хүрээлэн буй орчин болоод хүний биед хор нөлөөгүй химийн материалыг сонгон хэрэглэх нь орчин үеийн боловсруулах үйлдвэрүүдэд зайлшгүй тавигдах хариуцлагын асуудал болоод байна. Манай компани энэ тал дээр ихээхэн анхаарч туршилт судалгаа хийсний үндсэн дээр Испани улсын Cromogenia, Турк улсын Sarchem, Герман улсын Trumpler, Франц улсын ATC tannery chemicals, Хятад улсын Dowell зэрэг химийн материал бэлтгэн нийлүүлэгчтэй хамтран ажиллаж байна. Эдгээр компаниудаас химийн материал, будагч бодис авч байгаа хамгийн гол шалгуур нь байгаль орчин болоод хүний биед ээлтэй цэвэр технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэх юм.





Оролцож хэрэгжүүлсэн  
тодорхой үйл ажиллагаа

ШИНЭ  
ЭДИЙН  
ЗАСАГ

УВС  
САНГААЧИЛГА

Шинэ эдийн засаг-увс  
хамтын ажиллагааны  
санаачилга” бизнес  
форум-д оролцов

МОН-ИТ БУЛИГААР ХК НЬ УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМАНД 2020 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 18, 19-НИЙ ӨДРҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “ШИНЭ ЭДИЙН ЗАСАГ-УВС ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНААЧИЛГА” БИЗНЕС ФОРУМД ОРОЛЦОЖ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ СУРТАЛЧИЛАЖ, ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ УВС АЙМГИЙН ИРГЭДЭД ТАНИЛЦУУЛЛАА.






## Монгол экспорт экспо - 2020 үзэсгэлэн ярмаг худалдаа

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн-2020" үзэсгэлэн Мишээл Экспо төвд уламжлал ёсоор 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдлаа. Энэхүү үзэсгэлэн нь үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, үзэсгэлэн худалдааны цар хүрээг өргөжүүлэх, ноос, ноолуур, арьс ширний салбарын экспортын бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг нэг дороос худалдан авалт хийх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ХХААХҮЯам, Монголын Ноос Ноолуурын Холбоо, Монголын Арьс Ширний Үйлдвэрлэлийн Холбоо, Мишээл Экспо хамтран зохион байгуулсан юм.

Манай компани нь тус үзэсгэлэн ярмаг худалдаанд арьс шир үйлдвэрлэгч нарыг төлөөлөн оролцож, үндэсний үйлдвэрлэлийг худалдан авагч нарт илүү ойроос авах боломжоор хангаж ажиллаа.



2020 оны 10 дугаар сард манай компани нь арьс ширээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарт зориулж 2 дах удаагаа LEATHER PARTNERS-2020 EVENT-ийг зохион байгууллаа.

Энэ удаад арьс ширээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 70-аад аж ахуй нэгж, хувиараа бизнес эрхлэгчид оролцсоноор онцлог байв. LEATHER PARTNERS-2020 EVENT нь Хамтын хүч, Салбарын хөгжил уриан дор явагдаж дотоодын арьс ширээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарыг зөвхөн монголд үйлдвэрлэсэн арьс ширээр хангах зорилготойгоор зохион байгуулагдлаа.





Мон-Ит Булигаар ХК-ийн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнтэй бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид танилцаж байна.



Мон-Ит Булигаар ХК-ийн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнтэй бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид танилцаж байна.



Мон-Ит Булигаар ХК-ийн боловсруулсан арьс ширээр хийсэн цүнх,  
жижиг эдлэл



Мон-Ит Булигаар ХК-ийн боловсруулсан арьс ширээр хийсэн бүх  
төрлийн гутал

